



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 13 өдөр

Дугаар 4/915

Мандалговь

Гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн Аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай 01 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтад батлагдсан орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Үйлчилгээний нэгдсэн төвийн тоног төхөөрөмж”-ийн ажлын гэрээг “Нью элек сервис” ХХК-тай 19,804,400 (арван есөн сая найман зуун дөрвөн мянга дөрвөн зуу) төгрөгөөр байгуулсугай.

2. Үнийн саналын дагуу тоног төхөөрөмжийг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Нью элек сервис” ХХК (Б.Эзэнболд)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай байгуулсан гэрээнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Доржбат), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхтайван)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4823100636